



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/505

Булган сум

Аймгийн Нийтийн номын сангийн
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 5,6,7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 09 дүгээр албан даалгаврын дагуу Аймгийн Нийтийн номын сангийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллагсдын цалин хөлс, ажиллах орчин, нөхцөлийг батлагдсан төсвийн хүрээнд бүрдүүлж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх), Нийтийн номын сангийн захирал (Т.Мөнгөнтуяа) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхлэхийг Нийтийн номын сангийн захиралд зөвшөөрсүгэй.

5. Тус захирамж гарсантай холбогдуулан 2012 оны А/120 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 22-ны/ний өдрийн
А/505 дугаар захирамжийн хавсралт

Аймгийн Нийтийн номын сангийн бүтэц орон тоо

Д/д	Албан тушаалын нэр	Ангилал зэрэглэл	Орон тоо
1	2	3	4
1	Захирал	ТҮСБ-6	1
2	Арга зүйч	ТҮСБ-4	1
3	Ном зүйч	ТҮСБ-4	1
4	Сүлжээний инженер, мэдээлэл технологийн ажилтан	ТҮСБ-4	1
5	Сан хөмрөгч	ТҮСБ-4	1
6	Нийтийн уншлагын танхимын номын санч мэдээллийн ажилтан	ТҮСБ-3	2
7	Хүүхдийн уншлагын танхимын номын санч мэдээллийн ажилтан	ТҮСБ-3	2
8	Гэр бүлийн уншлагын танхимын номын санч мэдээллийн ажилтан	ТҮСБ-3	2
9	Нягтлан бодогч	ТҮМ-6	1
10	Архив-бичиг хэргийн ажилтан, нярав	ТҮМ-3	1
11	Сантехникч /гэрээгээр/	ТҮ-3	1
12	Цахилгаанчин /гэрээгээр/	ТҮ-3	1
13	Үйлчлэгч	ТҮ-1	2
	Бүгд		17